



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
4.1 Залруулсан алдаа .....	17
4.2 Төлбөрийн акт .....	17
4.3 Албан шаардлага .....	17
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЭМГ	Эрүүл мэндийн газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/270  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
РЕНЧИНЛХҮМБЭ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Б.НАНСАЛМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн Ковидын цогц тусламж үйлчилгээний урсгал төсвийн зардлын санхүүжилтээс төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр 60.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч нэмэлт төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасан нийцээгүй.
2. Нягтлан бодогч Н.Мөнхжаргал нь Ренчинлхүмбэ сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогчийн сарын үндсэн цалин 0.8 төгрөг, мөн сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогчийн сарын үндсэн цалин 0.8 сая төгрөг, нийт 1.6 сая төгрөгөөр давхар цалинжсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, 109 дүгээр зүйлийн 109.6 дугаар заалт, Засгийн газрын 2019 оны 9-р тогтоолтой тус тус нийцээгүй.
3. Шалгагдагч байгууллага төсвийн хөрөнгөөр 60.6 сая төгрөгийн үнэтэй ЭХО аппаратыг худалдан авахдаа эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гэрээ шууд байгуулах аргаар худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлтэй нийцээгүй байгаа нь *нийцсэн бөгөөд зохистой* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөг/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>81,652,110.39</b>	<b>198,821,351.07</b>	
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>00.00</b>	<b>14,189,097.33</b>	
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>00.00</b>	<b>14,189,097.33</b>	
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>00.00</b>	<b>14,189,097.33</b>	
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,245,762.33	
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	12,943,335.00	
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,398,100.00</b>	<b>61,805,200.00</b>	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	00.00	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>80,254,010.39</b>	<b>122,827,053.74</b>	
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>28,579,779.08</b>	<b>55,590,557.67</b>	
35130	Эм боох материал	22,095,394.76	49,106,173.35	
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>51,674,231.31</b>	<b>67,236,496.07</b>	
35410	Бичиг хэргийн материал	1,206,800.00	2,695,570.00	
35420	Аж ахуйн материал	31,495,478.51	50,310,060.22	
35440	Түлш, шатах тослох материал	12,823,440.00	4,868,950.30	
35460	Хүнсний материал	2,918,512.80	1,131,915.55	
35470	Бусад хангамжийн материал	2,030,000.00	2,030,000.00	
35600	Мал амьтад	00.00	00.00	
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>333,944,233.12</b>	<b>421,546,622.77</b>	
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>333,944,233.12</b>	<b>421,546,622.77</b>	
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>304,515,483.24</b>	<b>391,636,622.77</b>	
39201	Барилга, байгууламж, орон сууц	206,325,849.00	206,325,849.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	-79,827,337.56	-99,404,638.84	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	207,352,527.00	297,206,508.56	
39206	Хуримтлагдсан элэгдэл	-128,417,620.14	-93,843,896.05	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,843,714.27	21,714,079.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,718,266.61	-11,888,144.19	
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,709,179.00	6,709,179.00	
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,304,927.00	-5,655,990.00	
39217	Ном	00.00	00.00	
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>29,428,749.88</b>	<b>29,910,000.00</b>	
39301	Програм хангамж	15,825,000.00	825,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	-15,756,250.12	-275,000.00	
39303	Бусад биет бус хөрөнгө	29,360,000.00	29,360,000.00	
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>415,596,343.51</b>	<b>620,367,973.84</b>	
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,031,029.40</b>	
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>2,031,029.40</b>	
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>2,031,029.40</b>	
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,694,179.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>415,596,343.51</b>	<b>618,336,944.44</b>	
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>415,596,343.51</b>	<b>618,336,944.44</b>	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	269,328,439.00	269,328,439.00	
51101	Өмч: - төрийн	269,328,439.00	269,328,439.00	
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>9,959,992.37</b>	<b>248,308,287.64</b>	
51210	Өмнөх үеийн үр дүн	9,959,992.37	45,567,686.71	
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	202,740,600.93	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	136,307,912.14	100,700,217.80	
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>415,596,343.51</b>	<b>620,367,973.84</b>	

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/төгрөг/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>643,557,746.13</b>	<b>1,262,727,276.46</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>90,127,836.13</b>	<b>422,048,756.46</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>90,127,836.13</b>	<b>422,048,756.46</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,127,836.13	422,048,756.46
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	61,805,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,127,836.13	360,243,556.46
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>71,204,010.00</b>	<b>344,672,220.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	482,225,900.00	496,006,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,398,100.00</b>	<b>70,961,010.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	43,700.00	11,078,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,354,400.00	47,681,810.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	12,201,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,744,000.00</b>	<b>18,744,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,744,000.00	18,744,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>49,061,910.00</b>	<b>254,967,210.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,061,910.00	254,967,210.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>586,873,801.70</b>	<b>1,051,726,555.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>586,873,801.70</b>	<b>1,051,726,555.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>580,694,679.53</b>	<b>1,011,926,555.09</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>365,008,198.83</b>	<b>447,933,629.00</b>
210101	Үндсэн цалин	234,048,352.56	447,933,629.00
210102	Нэмэгдэл	111,622,416.22	00.00
210104	Урамшуулал	19,337,430.05	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,866,676.00</b>	<b>58,384,511.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,570,254.00	42,312,618.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,831,794.00	3,986,339.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,952,036.00	3,417,373.00
210204	Ажилгүйдлийн даатгал	696,103.00	770,165.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,816,489.00	7,898,016.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,813,861.25</b>	<b>16,654,594.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,379,600.00	2,529,594.00
210302	Түлш, халаалт	7,233,861.25	12,925,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,400.00	1,200,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,423,236.71</b>	<b>59,305,489.17</b>
210401	Бичиг хэрэг	2,641,400.00	1,239,020.00
210402	Тээвэр, шатахуун	21,294,190.00	27,078,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,394,309.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,129,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,110,837.50	27,465,079.50
210408	Бараа материал акталсны зардал	3,176,809.21	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>55,452,959.29</b>	<b>339,722,434.45</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,997,250.79	321,926,087.20
210502	Хоол, хүнс	10,455,708.50	15,802,347.25

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,994,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,421,500.00</b>	<b>3,669,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	170,000.00
210604	Урсгал засвар	3,421,500.00	3,499,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>634,000.00</b>	<b>1,474,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	634,000.00	1,474,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,078,286.00</b>	<b>958,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,566,206.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	85,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	247,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	506,000.00
210807	Газрын төлбөр	62,080.00	65,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>36,995,961.45</b>	<b>83,824,097.47</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,356,980.00	9,961,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,638,981.45	73,863,047.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,179,122.17</b>	<b>39,800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>39,800,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	39,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,179,022.17</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,179,022.17	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>100.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	100.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>56,683,944.43</b>	<b>211,000,721.37</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>8,260,120.44</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	8,260,120.44
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-8,260,120.44</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>56,683,944.43</b>	<b>202,740,600.93</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	9,959,992.37	415,596,343.51
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	9,959,992.37	415,596,343.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	35,607,694.34	35,607,694.34
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,328,439.00	45,567,686.71	451,204,037.85
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-35,607,694.34
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	202,740,600.93	202,740,600.93
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	269,328,439.00	248,308,287.64	618,336,944.44

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>553,429,910.00</b>	<b>842,076,620.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>553,429,910.00</b>	<b>842,076,620.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	482,225,900.00	496,006,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,398,100.00</b>	<b>72,359,110.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	43,700.00	11,078,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,354,400.00	49,079,910.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	12,201,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,744,000.00</b>	<b>18,744,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,744,000.00	18,744,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>49,061,910.00</b>	<b>254,967,210.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,061,910.00	254,967,210.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>550,201,810.00</b>	<b>741,587,522.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>550,201,810.00</b>	<b>741,587,522.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>544,022,687.83</b>	<b>701,787,522.67</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>364,982,492.83</b>	<b>443,527,182.00</b>
210101	Үндсэн цалин	234,022,646.56	299,529,003.00
210102	Нэмэгдэл	111,622,416.22	95,170,600.00
210104	Урамшуулал	19,337,430.05	23,725,779.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	25,101,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,866,676.00</b>	<b>61,096,779.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,570,254.00	44,786,911.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,831,794.00	4,077,467.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,952,036.00	3,261,934.00
210204	Ажилгүйдлийн даатгал	696,103.00	815,533.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,816,489.00	8,154,934.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,244,000.00</b>	<b>14,023,544.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,379,600.00	2,529,594.00
210302	Түлш, халаалт	10,664,000.00	10,293,950.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,400.00	1,200,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,647,230.00</b>	<b>52,093,239.67</b>
210401	Бичиг хэрэг	3,600,000.00	2,235,690.00
210402	Тээвэр, шатахуун	26,617,230.00	21,560,940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,394,309.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,230,000.00	24,302,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>40,211,600.00</b>	<b>107,983,628.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,851,600.00	92,310,728.00
210502	Хоол, хүнс	11,480,000.00	13,678,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,880,000.00	1,994,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,499,900.00</b>	<b>10,229,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	735,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	995,000.00

210604	Урсгал засвар	5,499,900.00	8,499,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>634,000.00</b>	<b>1,474,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	634,000.00	1,474,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,890,809.00</b>	<b>1,246,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,786,729.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	85,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,000.00	247,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	506,000.00
210807	Газрын төлбөр	62,080.00	65,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	400,000.00	288,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,045,980.00</b>	<b>10,112,650.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,045,980.00	10,112,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,179,122.17</b>	<b>39,800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>39,800,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	39,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>6,179,022.17</b>	<b>00.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,179,022.17	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>100.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	100.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>3,228,100.00</b>	<b>100,489,097.33</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,830,000.00</b>	<b>86,300,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,830,000.00</b>	<b>86,300,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,830,000.00</b>	<b>86,300,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,830,000.00	86,300,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-1,830,000.00</b>	<b>-86,300,000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,398,100.00</b>	<b>14,189,097.33</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>14,189,097.33</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь /төгрөг/
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	566,487,300.0	553,816,947.7	12,670,352.3	97.8
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	566,487,300.0	553,816,947.7	12,670,352.3	97.8
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	566,487,300.0	553,816,947.7	12,670,352.3	97.8
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	392,181,800.0	392,127,579.0	54,221.0	100.0
210101	Үндсэн цалин	248,129,400.0	248,129,400.0	00.0	100.0
210102	Нэмэгдэл	95,170,600.0	95,170,600.0	00.0	100.0
210104	Урамшуулал	23,780,000.0	23,725,779.0	54,221.0	99.8
210105	Гэрээт ажлын хөлс	25,101,800.0	25,101,800.0	00.0	100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,944,600.0	52,944,600.0	00.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	37,257,400.0	37,257,400.0	00.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,921,800.0	3,921,800.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,137,400.0	3,137,400.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	784,400.0	784,400.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,843,600.0	7,843,600.0	00.0	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,144,000.0	14,023,544.0	1,120,456.0	92.6
210301	Гэрэл, цахилгаан	3,650,000.0	2,529,594.0	1,120,406.0	69.3
210302	Түлш, халаалт	10,294,000.0	10,293,950.0	50.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.0	1,200,000.0	00.0	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,175,000.0	30,216,839.7	4,958,160.3	85.9
210401	Бичиг хэрэг	2,240,000.0	2,235,690.0	4,310.0	99.8
210402	Тээвэр, шатахуун	26,175,000.0	20,636,840.0	5,538,160.0	78.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,760,000.0	2,394,309.7	365,690.3	86.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.0	1,600,000.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.0	3,350,000.0	-950,000.0	139.6
2105	<b>Нормативт зардал</b>	52,507,900.0	49,969,335.0	2,538,565.0	95.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,328,000.0	34,296,435.0	31,565.0	99.9
210502	Хоол, хүнс	13,679,900.0	13,678,900.0	1,000.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.0	1,994,000.0	2,506,000.0	44.3
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,000,000.0	4,494,800.0	2,505,200.0	64.2
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,500,000.0	995,000.0	2,505,000.0	28.4
210604	Урсгал засвар	3,500,000.0	3,499,800.0	200.0	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.0	988,000.0	12,000.0	98.8
210702	Дотоод албан томилолт	1,000,000.0	988,000.0	12,000.0	98.8

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,652,000.0	1,246,700.0	405,300.0	75.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	00.0	400,000.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	85,000.0	85,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,000.0	247,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	55,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	506,000.0	506,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	65,000.0	65,000.0	00.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	294,000.0	288,700.0	5,300.0	98.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,882,000.0	7,805,550.0	1,076,450.0	87.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,882,000.0	7,805,550.0	1,076,450.0	87.9
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	564,087,300.0	555,062,710.0	9,024,590.0	98.4
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	496,006,300.0	496,006,300.0	00.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	496,006,300.0	496,006,300.0	00.0	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	18,744,000.0	18,744,000.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	18,744,000.0	18,744,000.0	00.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	49,337,000.0	40,312,410.0	9,024,590.0	81.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,337,000.0	40,312,410.0	9,024,590.0	81.7
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	1,245,762.33	-1,245,762.3	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	29.00	29.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөг/
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>274,070,575.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>274,070,575.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>234,270,575.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>51,399,603.00</b>
210101	Үндсэн цалин	51,399,603.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,152,179.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,529,511.00
210202	Тэтгэмжийн даатгал	155,667.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	124,534.00
210204	Ажилгүйдлийн даатгал	31,133.00
210205	Эрүүл мэндийн даатгал	311,334.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,436,400.00</b>

210402	Тээвэр, шатахуун	924,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,512,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>58,014,293.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,014,293.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>91,475,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	86,475,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>486,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	486,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,307,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,307,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,800,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	39,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>287,013,910.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>72,359,110.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,947,900.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	214,654,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,079,910.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,331,300.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,943,335.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн бараа материалын үлдэгдэл, худалдан авалттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор Г.Мөнхбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/А/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамж” 2021 оны А-243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө муу байна гэж дүгнэлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,051.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай болсон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 204.4 сая төгрөгөөр буюу 49.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	14.2	14.2
Авлага	1.4	61.8	60.4
Бараа материал	80.2	122.8	42.6
Биет хөрөнгө	304.5	391.6	87.1
Биет бус хөрөнгө	29.4	29.9	0.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>415.6</b>	<b>620.0</b>	<b>204.4</b>
Хуримтлагдсан үр дүн	<b>9.9</b>	248.3	237.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>415.6</b>	620.0	204.4

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14.1 сая төгрөг байгааг Төрийн сантай тулган баталгаажуулсан байна.

Авлагын үлдэгдэл 60.4 сая төгрөгөөр нэмэгдэж 61.8 сая төгрөг байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангаас ковид цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээний санхүүжилтийн авлага байна. Энэ авлагын тооцоог нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 42.6 сая төгрөгөөр өсөж 122.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан эм боох материал 93.0 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн авсан вакцин, эм тариа 256.2 сая төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан түлш шатах тослох материал 30.9 сая төгрөг,
- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хүнсний материал 14.0 сая төгрөг төгрөг,
- Бусад хангамжийн материал 69.6 сая төгрөг,
- Тайлант хугацаанд нийт 421.2 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Биет хөрөнгийн үлдэгдэл 87.1 сая төгрөгөөр өсөж 391.6 сая төгрөг болсон. Үүнд материаллаг нөлөөтэй биет хөрөнгийг харуулбал:

- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 01-ний өдрийн А/741 тоот тушаалаар “Монпэн” төслийн хүрээнд тавилга, хэрэгсэл, компьютер техник хэрэгсэл 18.8 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А/90 тоот тушаалаар зөөврийн технологи 3.6 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 сарын 7-ны өдрийн А/148 тоот тушаалаар дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж 4.8 сая төгрөг тус тус хүлээн авсан бол
- Тайлант хугацаанд Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 05 сарын 04-ны өдрийн А/121 тоот тушаалаар 6.5 сая төгрөгийн мотоцикль.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн Ковидын цогц тусламж үйлчилгээний урсгал төсвийн зардлын санхүүжилтээс ТЕЗ -ийн шийдвэргүйгээр нийт 77.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч нэмэлт төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.
- Биет бус хөрөнгийн материаллаг нөлөөтэй өөрчлөлтийг харуулбал: Аймгийн ИТХ-ын 118 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 28 дугаар тогтоолоор 15.0 сая төгрөгийн өртөгтэй “Цахим эрүүл мэнд” программыг акталж данснаас хассан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 564.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг мөн үнийн дүнгээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсөв захирагч 2021 оны төсвийн төслийг бууруулан 564.1 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 496.0 сая төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 18.7 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 49.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийг нийт 555.1 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Улсын төсвөөс 496.0 сая төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 18.7 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 40.3 сая төгрөгийн санхүүжилт олгож 9.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.
- Төсвийн санхүүжилтийн орлогын үлдэгдэл 1.3 сая төгрөг харилцах дансанд үлдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт 287.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Тухайн байгууллагын дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 49.1 сая төгрөг хуваарилсан байна. Үүнд: ЭМГ-ын даргын А/45-р тушаалаар олгосон илүү цагийн хөлс 3.6 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/496 тоот тушаал, ЭМГ-ын даргын 2021 оны А/114 тоот тушаалаар олгосон нэг удаагийн тэтгэмж урамшуулал 39.0 сая төгрөг байна. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268-р тушаалын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 214.6 сая төгрөг, бусад хандив тусламж 9.9 төгрөгийн хөрөнгийг тус тус хуваарилсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал, үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Корона вирус -2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан. Ковидын тархалттай холбогдсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 375 хүн өвчилж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 4066 тун вакцинд иргэдийг хамруулж нийт 276.4 төгрөг нэхэмжилснээс 214.6 сая төгрөгийн санхүүжилт авч 61.8 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

- Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268-р тушаалын дагуу олгосон ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 214.6 сая төгрөг нь эмч, эмнэлгийн ажилчдын цалин, эм урвалж бусад урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалттай байна. Гэтэл Эрүүл мэндийн даатгалын сангийн Ковидын цогц тусламж үйлчилгээний урсгал төсвийн зардлын санхүүжилтээс ТЕЗ -ийн шийдвэргүйгээр 60.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч нэмэлт төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь нь “Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан “Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх, мөн хуулийн 16.5.5.-д заасан батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг зөрчсөн байна.
- Нягтлан бодогч Мөнхжаргал нь Ренчинлхүмбэ сумын Засаг даргын тамгын газрын Нягтлан бодогч, сарын үндсэн цалин 0.8 сая төгрөг, мөн сумын ЭМТ-ийн Нягтлан бодогч, сарын үндсэн цалин 0.8 сая төгрөг, нийт 1.6 сая төгрөгөөр давхар цалинжсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2, 109.6 дугаар заалт, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолыг тус тус зөрчсөн байна.
- Шалгагдагч байгууллага төсвийн хөрөнгөөр 60.6 сая төгрөгийн үнэтэй ЭХО аппаратыг худалдан авахдаа эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гэрээ шууд байгуулах аргаар худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийг зөрчсөн байна.
- Тайлант хугацаанд Төрийн сангийн харилцах дансанд 14.2 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас

бусад тохиолдолд төсвийн жил дуусахад болох бөгөөд захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 хамаарах төсөвт байгууллага төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 702.1 сая төгрөгийн 146 мэдээллийг оруулахаас 89.9 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгахад:

- Эмч, эмнэлгийн ажилчдын нэмэгдэл урамшуулал болох 51 сая төгрөгийн цалин хөлс нэмэгдэл урамшилд хувь хүний орлогын албан татвар ногдуулалгүй тайлагнасан зөрчил илэрсэн нь хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна. Энэ зөрчлийг аудитын хугацаанд залруулсан.
- Эд хөрөнгийн тооллогын бүртгэлээс түүвэрлэн эм, эмнэлгийн хэрэгслийн тооллогыг шалгахад дутуу хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан Нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилж тус тушаалаар өмнөх тушаалууд хүчингүй болсон байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2003 оны 114 дугаар тушаал, Сумдын эмнэлгийн статусыг өөрчлөх тухай 2011 оны 292 дугаар тушаал, Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2013 оны 256 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосон байна. Үүнтэй холбогдуулан ЭМЯ-ны сайдын А/540 дугаар тушаалаар сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амын хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах журам гарсантай холбогдуулан сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна. Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын хүн эмнэлэг нэртэйгээр үйл ажиллагааг явуулж байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалтай зөрчилдөж байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайланг Ихэр мөрөн аудит ХХК аудит хийж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн биет хөрөнгө данснаас хасах, дахин үнэлэх, ашиглагдахгүй байгаа биет бус хөрөнгө, шилэн дансны хугацаа хоцролтыг зогсоох талаар 3 зөвлөмж өгсний 2 зөвлөмжийг хэрэгжүүлж шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж Улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх оноосон нэрийг өөрчилсөн байхыг анхаарч үзэх.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 706.0 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 645.4 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 60.6 сая төгрөгийн 3 албан шаардлага өгсөн болно.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нийт 696.4 сая төгрөгийн 4 нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

1. Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 -р тушаалын дагуу олгосон ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 214.6 сая төгрөг нь эмч, эмнэлгийн ажилчдын цалин, эм урвалж бусад урсгал зардлыг санхүүжүүлэх зориулалттай байна. Гэтэл Эрүүл мэндийн даатгалын сангийн Ковидын цогц тусламж үйлчилгээний урсгал төсвийн зардлын санхүүжилтээс ТЕЗ -ийн шийдвэргүйгээр 60.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч нэмэлт төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь “Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан “Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх, мөн хуулийн 16.5.5.-д заасан батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг зөрчсөн зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Нягтлан бодогч Мөнхжаргал нь Ренчинлхүмбэ сумын Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч, сарын үндсэн цалин 0.8 сая төгрөг, мөн сумын ЭМТ-ийн нягтлан бодогч, сарын үндсэн цалин 0.8 сая төгрөг, нийт 1.6 төгрөгөөр давхар цалинжсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2, 109.6 дугаар заалт, Засгийн газрын 2019 оны 9-р тогтоолыг тус тус зөрчсөн байна, Иймд ажил албан тушаал хавсран ажиллахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2, 109.6 дугаар заалт, Засгийн газрын 2019 оны 9-р тогтоолыг мөрдөж ажиллах, зөрчил зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 702.1 сая төгрөгийн 146 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 89.9 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 хэсэгт заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн гүйцэт ил тод, хугацаанд нь мэдээлж байх албан шаардлага хүргүүлэв.

### **4. Зөвлөмж**

Зөвлөмж өгөөгүй болно.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ренчинлхүмбэ сумын эрүүл мэндийн төв	7	706.0	4	645.4	-	-	3	60.6	-	-

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.